



ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН САНХҮҮГИЙН НЭГДСЭН ТАЙЛАН

2013 он

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан Аймгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

Лавлах зүйлс байвал доорх хаягаар

холбоо барина уу:

Аймгийн Ерөнхий Аудитор

Л.Жаргалсайхан

Утас: 70272582

И-мэйл

Аудитын менежер

О.Амаржаргал

Утас: 70273463

И-мэйл

Аудитор

О.Сосор

Утас: 70273204

И-мэйл

АГУУЛГА

ХУУДАС

• Танилцуулга	1-7
• Санхүүгийн дотоод хяналт	7
• Гол шийдлүүд	8
• Залруулаагүй алдаа	8
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	8
• Аудитын санал дүгнэлт	8-

ТӨАГ-ын хаягийг оруулах

Төв аймаг Зуунмод сум 1-р баг Төрийн
байгууллагуудын ордон

Төв аймгийн Жаргалант сумын 2013 оны санхүүгийн нэгдсэн тайланд ААГ аудит хийж дууссан тухай мэдэгдэл

Бид Төв аймгийн Жаргалант сумын 2013 оны нэгдсэн санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Жаргалант сумын төсвийн ерөнхийлөн захирагчид энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Жаргалант сумын Удирдлага тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирдлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

- Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг **тодруулбал:**

НББ-ийн үе шат бүрд дээд шатны түвшний удирдлага хүрдэг эсэх, нийтлэг чанартай зардал, төсвийн санхүүжилт, өөрийн орлого, цалингийн зардал, өглөг, авлага, балансын үзүүлэлтүүд, үндсэн хөрөнгө, бараа материал, бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

- Гол илрүүлсэн зүйлс аудитын үр дүнгээс гарсныг **тодруулбал:**

- Мөнгөн харилцахын журналаас sort filter –ийг ашиглан эх үүсвэрийг тайлан тэнцэлд тусгасаныг шалгахад мөнгөн гүйлгээний тайланд орлого, санхүүжилтийг бүрэн тусгасан байна.

-

- МГТайланд НД-ийн байгууллагаас ирсэн листний 16885.1 мянган төгрөгийг орлого эх үүсвэр болон зарлагыг нэмэгдүүлэн тайлагнасан байсныг аудитын явцад залруулсан

- Үнэ төлбөргүй авсан 36868.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн орлогыг Сангийн сайдын 2013.12.02 ны өдрийн 269 тоот тушаалын дагуу Засгийн газрын оруулсан капитал дансны кт бичилтийг өөрчлөн орлого дансны кт болгон залруулах бичилт хийлгэсэн.

- Цэцэрлэг нь төсвийн гүйцэтгэлийн тайлангаар хоолны зардалд 137782.8 мянган төгрөг зарцуулахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 129942.3 мянган төгрөгийг зарцуулж зөрүү 7840.5 мянган төгрөгөөсактын төлбөрт 5571.3 мянган төгрөг шилжүүлж 2269.2 төгрөгийг

төвлөрүүлээгүй бараа материал бэлтгэсэн байсанд акт бичигдсэн.

-Сургуульд Авъяас хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан дугуйлан, секцийн цагийг илүү тооцон олгосон 1030.4 мянган төгрөгийн цалин олгосонд акт бичигдсэн.

- ЕМ, Санхүүгийн албаны даргаас ААГ тайлбар мэдүүлэг хүлээж байгаа

-Илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар тайлбар ирүүлнэ үү

Санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илэрээгүй тул Зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар Ерөнхий аудиторт санал оруулсан байгаа.

Аймгийн Ерөнхий Аудитор 2014 оны 03-р сарын 24-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад Ахлах нягтлан бодогч Л.Дуламсүрэн олон бусад бидэнтэй хамтран ажилласан ажиллагсдын байнгын дэмжлэг туслалцаа бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

Аудитор

О.Сосор

Төв аймгийн Аудитын Газар

2014.03.24

Танилцуулга

1. Бид Төв аймгийн Жаргалант сумын 2013 оны 12 дугаар сарын 31-р тасалбар болсон нэгдсэн санхүүгийн тайланд аудитаа хийж дуусаж байгаа ба санхүүгийн нэгдсэн тайланд ЗДТГ, Баг, ИТХурал, Сургууль, Цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төв, Мал хамгаалах сан, Сум хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах сан, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сан, Байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцааны сан, Орон нутгийн хөгжлийн сан, Эргэлтийн эмийн сангийн тайлангууд нэгтгэгдсэн байна. Жаргалант сумын удирдлагад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Жаргалант сумын удирдлага тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.

2. ААГ санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Жаргалант сумын хяналтыг ААГ-ын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм. Жаргалант сумын тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.

3. Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Жаргалант сумын удирдлагын анхаарлыг хандуулж байна.

Орлого, санхүүжилтийн талаар

Орлого санхүүжилтыг тайлан тэнцэлд бүрэн тусгасныг тулган шалгасан.

Мөнгөн харилцахын журналаас sort filter –ийг ашиглан эх үүсвэрийг тайлан тэнцэлд тусгасаныг шалгахад мөнгөн гүйлгээний тайланд орлого, санхүүжилтийг бүрэн тусгасан байна.

Сумын ИТХурлын 2012.12.21 ны өдрийн 03 тоот тогтоолоор 2013 оны орон нутгийн орлогыг 168691.6 мянган төгрөгөөр мянган төгрөгөөр батласан. 2013.12.20 ны өдрийн 04 тоот тогтоолоор орлогыг 13000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 181691.6 мянган төгрөгөөр баталсан. Гүйцэтгэлээр орон нутгийн орлогын дансанд 188750.9 мянган төгрөг төвлөрч орлогын төлөвлөгөө 7059.3 мянган төгрөг буюу 103.8 хувиар биелсэн байна.

Сумын ИТХурлын 2012.12.21 ны өдрийн 03 тоот тогтоолоор 2013 оны орон нутгийн төсвийн зарлагын нийт дүнг баталсан. Үүнд орон нутгийн удирдлага хэрэгжүүлэх зардал-331760.9 мянган төгрөг, нийгмийн халамжийн сан- 427694.0 мянган төгрөг, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал-12000.0 мянган төгрөгөөр, тусгай шилжүүлгийн дүн-1976435.4 мянган төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын өөрийн орлогыг -2169.5 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангаар зарцуулах хөрөнгийн хэмжээг 243200.0 мянган төгрөгөөр тус тус баталсан байна.

2013.08.09 ны өдрийн ИТХ-ын 5-р хуралдааны 04 тоот тогтоолоор НЕҮ-ний төсвийг 162060.0 мянган төгрөгөөр, 2013.12.20 ны 04 тоот тогтоолоор ЕБС-ын төсвийг 976547.0 мянган төгрөгөөр, өөрийн орлогыг 550.0 мянган төгрөг, нийт 977097.0 мянган төгрөг болгон өөрчлөж баталсан. ОНХСангийн санхүүжилтыг 204969.0 мянган төгрөг, хандивын орлогыг 55500.0 мянган төгрөг, нийт 260469.0 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

Сумын ИТХТэргүүлэгчдийн тогтоолийн дагуу Ажиллах хүчний төлбөрийн урьд оны үлдэгдлээс/2012оны/ Эмнэлэгт хурууны хээгээр цаг бүртгэгч-690.0 мянган төгрөг, тоног төхөөрөмж 2638.5 мянган төгрөг, сантехникийн засварт 2134.0 мянган төгрөг, нийт 5462.5 мянган төгрөг, ЕБС-д хөдөөгийн 2 багийн дотуур байрны сурагчдын тээвэрлэх шатахууны зардалд-3056.4 мянган төгрөг, гэрэлтүүлэг, монгол бичгийн тохижилтонд -4648.0 мянган төгрөг, машины урсгал засварт -971.0 мянган төгрөг, нийт 8675.4 мянган төгрөг, Соёлын төвд бодибилдингийн тоног төхөөрөмж 1300.0 мянган төгрөг, СӨБ-д Баянбулаг багт гадна талбайн тоглоом-15938.0 мянган төгрөг, Дэжид цэцэрлэгийн дээвэр солих-3659.0 мянган төгрөг, Төвийн цэцэрлэгийн тааз солиход -2678.0 мянган төгрөг, усны нөөцийн сав -1200.0 мянган төгрөг, нийт 23475.0 мянган төгрөг мөн Эмнэлгийн эхоны сургалтын төлбөр-280.0 мянган төгрөг, ОНТелевизийн тоног төхөөрөмж -980.2 мянган төгрөг, нийт ажиллах хүчний төлбөрөөс 40173.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2013 онд НЕҮйлчилгээнд төсвийн санхүүжилт 250069.3 мянган төгрөг, орон нутгийн орлогоос 258918.2 мянган төгрөг, бусад төсөвт байгууллагаас-75.0 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансаар 62087.0 мянган төгрөг, өөрийн орлого -1319.4 мянган төгрөг, урд оны үлдэгдлээс 3130.0 мянган төгрөг, нийт -578728.9 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэн зарцуулсан байна.

Улсын төсвийн /сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын төв/ байгууллагууд нь тусгай зориулалтын шилжүүлэгээр 1950392.0 мянган төгрөг, урьд оны хэмнэлтээс 3000.0 мянган төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого-2260.9 мянган төгрөг, нэмэлт төсвийн санхүүжилт -16425.8 мянган төгрөг, нийт 1972078.7 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэн зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө

2013 оны жилийн эцсийн нэгдсэн санхүүгийн тайланд оны эцэст бараа материалын үлдэгдэл 209600.3 мянган төгрөг, үндсэн хөрөнгө хуримтлагдсан элэгдэлийг хассанаар -3383118.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тусгагдсан байна.

Үндсэн хөрөнгө оны эхэнд 3423552.4 мянган төгрөг байсан. Тайлант онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар ЗДТГ-т Буурал болон Өгөөмөр багт 2 худаг шинээр гаргаж 29949.0 мянган төгрөг, Соёлын төвийн спорт залны засварт 88579.2 мянган төгрөгийн засвар хийгдсэнийг данс бүртгэлд тусгасан. Өгөөмөр багийн цэцэрлэгийн засварт 54616.6 мянган төгрөгийн засварыг Мөнх-алтай хайрхан ХХК хийж гүйцэтгэж, засварын ажлыг хүлээн авсан боловч хөрөнгө орлого авах тухай шийдвэр гараагүй тул дансанд тусгаагүй байсан. Сумын ИТХ-н 2013.12.05-ний өдрийн 03 тоот тогтоолоор нийт **9410.1** мянган төгрөгний үндсэн хөрөнгө акталж устгасан.

Бараа материал

Бараа материалын үлдэгдэл оны эхэнд 239652.7 мянган төгрөг байснаас оны эцэст – 209600.0 мянган төгрөг болж, оны эхнээс бараа материал 30052.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын орлогын гүйлгээг харилцах данснаас шилжүүлсэн тохиолдолд авлага өглөгийн дансаар дамжуулан бүртгэсэн байна. Бараа материал дансанд хөтлөгдөх анхан шатны баримтыг хэсэгчлэн шалгахад тайлан гаргалт, баримт бүрдүүлэлт орлого, зарлагын баримт, шаардах хуудасанд зөвшөөрсөн, олгосон хүний гарын үсэг бүрэн зурагдсан баримтын бүрдэл сайн, нярав нэр төрлийн тайланг сар бүр гаргасан байна. Тооллогын комисс нь Эд хөрөнгийн тооллогын бүртгэл /НХМаягт БМ-8/ -ийг хөтөлж тооллого тооллогын бүртгэлд тооллогын комисс гарын үсэг зурсан. Тооцоо бодсон актыг данс бүрээр бодсон байна.

Бараа үйлчилгээний зардал

Бараа үйлчилгээний зардлуудыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудаас ирүүлсэн нэхэмжлэхийн дагуу шилжүүлсэн байна.

Эрүүл мэндийн төв нь төсөл хөтөлбөрийн зардлыг зориулалтын дагуу зарцуулалгүй автомашины сэлбэг худалдан авахад 340.8 мянган төгрөг, ахмадууд хүлээн авахад 180.0 мянган төгрөг, хүнсний материалд 611.0 мянган төгрөгийг зарцуулсан байсан.

Сургуульд нүүрсний зарцуулалтыг шалгахад Шарын гол ХК-иас 2013 онд 84.1 тн буюу 4210.2 мянган төгрөгийн нүүрс худалдан авсан байна. 2013.12.19 ноос 2013.12.31 ны хооронд 5 удаагийн рейссээр 50 тн 2502.5 мянган төгрөгийн нүүрс татан авч орлогодсон байна. Гэтэл 2013.12.31 нд 50.0 тн нүүрсийг зөвхөн зарлагын падаан бичиж зарлагадсан зөрчил илэрсэн.

Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн тайлан гаргалт анхан шатны баримтын бүрдлийг хэсэгчлэн шалгахад мөнгөн хөрөнгөнд хөтлөгдөх анхан шатны баримтыг зохих журмын дагуу бүрдүүлсэн байна. Төрийн сангаас гүйлгээ хийсэн баримт бүрт төрийн сангийн тэмдэг дарж баталгаажуулсан байна.

Орон нутгийн орлогын дансны эхний үлдэгдэл 114448.4 мянган төгрөг, тайлант онд орон нутгийн орлогоор 188750.9 мянган төгрөг/ үүнээс Тэн хун ХХК-иас Ажиллах хүчний төлбөр 106640.0 мянган төгрөг/- ийн орлого орсон байна. Орлогын данснаас НЕҮйлчилгээнд 258918.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож, дансны үлдэгдэл 42962.2 мянган төгрөгийг ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн.

НЕҮйлчилгээний байгууллагууд /ЗДТГ 11053.1 мянган төгрөг, Баг -1042.0 мянган төгрөг, ИТХурал-2138.8 мянган төгрөг, Байгаль хамгаалх зардал-5626.4 мян.төгрөг, /-19860.3 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжсэн улсын төсвийн байгууллагууд /Цэцэрлэгүүд-4242.3 мян.төгрөг, ЕБСургууль-5129.2 мян.төгрөг, Эмнэлэг-18.0 мян.төгрөг, Соёлын төв -257.4 мянган төгрөг/ -9646.9 мянган төгрөгийг тус тус төсөвт төвлөрүүлсэн байна. Орон нутгийн нэгдсэн санхүүгийн тайлангийн 2013 оны 12-р сарын 31-ний байдлаар мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэлт санхүүжилтын харилцах дансны үлдэгдэл-2723.5 мянган төгрөг байна. Орон нутгийн ерөнхий орлогын дансны

үлдэгдэл 43762.2 мянган төгрөг, тусгай зориулалтын сангуудын үлдэгдэл - 51051.9 мянган төгрөг, нийт 97537.6 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Авлага ,өглөгийн талаар

Авлага өглөгийн журналыг ерөнхий дэвтрийн данстай тулган баталгаажуулсан.

Ажил гүйлгээг тухай бүрд нь өглөг, авлага үүсгэн бүртгэсэн. 2013 оны жилийн эцсийн нэгдсэн санхүүгийн тайланд авлага оны эхэнд 138994.5 мянган төгрөг, жилийн эцэст 284203.6 мянган төгрөг болж авлага оны эхнээс 145209.0 мянган төгрөгөөр буюу 51 хувиар өссөн байна. Нийт авлагын 282237.2 мянган төгрөг буюу 99.3 хувийг сум хөгжүүлэх сангаас олгосон зээл болон зээлийн хүүгийн авлага эзэлж байна.

Өглөг оны эхэнд 7581.3 мянган төгрөг, тайлант онд 6570.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст 14151.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжилтын дутуугаас Өгөөмөр багийн цэцэрлэгийн засварын ажлын үлдэгдэл Мөнх-алтай хайрхан ХХК-д өгөх өглөг -14016.7 мянган төгрөг нийт өглөгийн 99.0 хувийг эзлэж байна.

9.Тусгай зориулалтын сангуудын талаар

ГХУС сангийн эхний үлдэгдэл 973.7 мянган төгрөг, тайлант онд 3281.1 мянган төгрөгийн санхүүжилт хийгдэж, шатахуунд 1252.9 мянган төгрөг, томилолт-35.5 мянган төгрөг, уралдан тэмцээнд 517.6 мянган төгрөг, бусад төсөл арга хэмжээнд 1090.0 мянган төгрөг, нийт 3271.3 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 983.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Мал хамгаалах сангийн эхний үлдэгдэл-8585.2 мянган төгрөг, тайлант онд 158.8 мянган төгрөгийн орлого орж, өвсний фонд бүрдүүлэхэд зориулан 2700.0 мянган төгрөгөөр өвс худалдан авсан. тээвэр шатахуунд 2462.7 мянган төгрөг, мэдээлэл суртчилгаанд 108.5 мянган төгрөг, 3261.2 мянган төгрөг бусад төсөл арга хэмжээнд зарцуулсан. Оны эцэст 91.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Байгаль хамгаалах сангийн оны эхний үлдэгдэл 10779.5 мянган төгрөг, тайлант онд аймгаас санхүүжилт 12000.0 мянган төгрөг, бусад орлогоор 5472.7 мянган төгрөгийн орлого орж, шатахуунд-6447.5 мянган төгрөг, нормын хувцасанд-755.0 мянган төгрөг, төлбөр хураамж-368.2 мянган төгрөг, урсгал засварт 280.0 мянган төгрөг, мэдээлэл суртчилгааны зардалд 175.0, бусад зардалд 2226.8 мянган төгрөг, байгалт орчныг нөхөн сэргээх арга хэмжээнд 5573.6 мянган төгрөг зарцуулж, 5626.4 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж, 800.0 мянган төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн. Оны эцэст 6019.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

БОНС Барьцаа сан нь оны эхэнд 1275.0 мянган төгрөгний үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант хугацаанд Хавчуу ланд монголио ХХК-иас нөхөн сэргээлтийн барьцаанд 250.0 мянган төгрөгийн орлого орж, 1525.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Орон нутгийн хөгжлийн сан. Жаргалант сумын ИТХурлын 2013 оны 02-р сарын 21 өдрийн 02 тоот тогтоолоор сумын орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулах үндсэн зарчмын баримталж үр ашгийг аль болох олон иргэд хүртэх

цаашид үр ашиг нь үргэлжлэх байдлыг харгалзан хөрөнгө оруулалтын чиглэлээр эрэмбэлсэн 7 ажлын жагсаалтыг 243200.0 мянган төгрөгөөр батласан байна. 2013.12.20 ны өдрийн Сумын ИТХ-ын 8-р хуралдаанаар тодотгон 204969.0 мянган төгрөг, хандив тусламжаар 55500.0 мянган төгрөгөөр, нийт 260469.0 мянган төгрөгөөр баталсан.

Тайлант хугацаанд төвлөрсөн төсвөөс санхүүжилт-201470.9 мянган төгрөг, хандив тусламж бусад орлогоос- 65353.6 мянган төгрөг, нийт 266824.5 мянган төгрөгийн санхүүжилт авч 255677.7 мянган төгрөгийг зарцуулж 25163.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна

Сум хөгжүүлэх сангийн оны эхний үлдэгдэл 78490.4 мянган төгрөг, тайлант онд 75000.0 мянган төгрөгийн урсгал төсвийн санхүүжилт, зээл-96114.6 мянган төгрөг, зээлийн хүүгийн орлогод 7665.7 мянган төгрөг, алданга-771.6 мянган төгрөг, нийт 180123.9 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлсэн. Тайлант онд 245071.8 мянган төгрөгийн зээл олгож, Цалин НДШ-д 666.0 мянган төгрөг, шатахуунд 351.2 мянган төгрөг, бусад зардалд 73.0 мянган төгрөг, нийт 246162.1 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 12452.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Зээлийн авлага 88 иргэнээс авах 282237.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Эргэлтийн эмийн сан. Борлуулалт болон худалдан авагчаас орсон мөнгө - 15079.8 мянган төгрөг орж 11936.9 мянган төгрөгийг зарцуулж 4816.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Тусгай зориулалтын нийт сангуудын оны эцсийн үлдэгдэл-51051.9 мянган төгрөгөөр тайлагнасан нь тайлан тэнцлийн дүнтэй тохирч байна.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

5. Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

6. Эдгээр асуудлуудыг ААГ болон Жаргалант сумын удирдлага авч үзэж хангалттайгаар шийдсэн. Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрөхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

7. Аудитын стандарт нь ААГ-г аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Аудитаар залруулаагүй алдаа гараагүй болно.

Тайлбар мэдүүлгийн захидал

8. Аудитын үйл явцад ААГ хөндлөнгийн аудиторовн хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ санхүү бүртгэлийн ажилтанаас эдгээр баталгааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Аудитын санал дүгнэлт

9. Аймгийн Аудитын газраас тус тайланд **зөрчилгүй** санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

Аймгийн Аудитын газар
2014.03.24